



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 36 (321)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай*
- *Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай*
- *Тогтоолд өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2003 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2003 оны есдүгээр сарын 29

№ 36 (321)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

522. Хуан Зякуйг "Алтан гадас" одонгоор
шагнах тухай Дугаар 169 837

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

523. Улсын Их Хурлын 2003 оны намрын
зэлжит чуулганаар хэлэлцэх асуудлын
дараалал тогтоох тухай Дугаар 127 838

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

524. Тогтоолын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай Дугаар 195 838
525. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт
бодисын эргэлтэд хяналт тавих тухай
хуулийг хэрэгжүүлэх зарим арга
хэмжээний тухай Дугаар 196 840
526. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Дугаар 198 844

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 9 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 169

Улаанбаатар
хот

Хуан Зякуйг "Алтан гадас" одонгоор
шагнах тухай

Монгол Улс, БНХАУ-ын харилцаа, хамтын
ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оруулж байгаа
хувь нэмрийг нь үнэлж БНХАУ-аас Монгол Улсад
суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Хуан

Зякуйг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2003 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр

Дугаар 127

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт, Улсын Их Хурлын 2003 оны 36 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Их Хурлын 2003 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг дор дурдсанаар тогтоосугай:

1/ Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг төсөл;

2/ Биеийн тамир спортын тухай хуулийн төсөл;

3/ Иод дутлын эмгэгээс сэргийлэх тухай хуулийн төсөл;

4/ Рашааны тухай хуулийн төсөл;

5/ Баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн төсөл;

6/ Монгол Улсын 2004 оны улсын төсвийн тухай хуулийн төсөл;

7/ Монгол Улсын эдийн засаг, Нийгмийг 2004 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг төсөл;

8/ Төрөөс мөнгөний бодлогын талаар 2004 онд баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг төсөл;

9/ Тариалангийн тухай хуулийн

Улсын Их Хурлын 2003 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай

төсөл;

10/ Ахуйн болон үйлдвэрлэлийн хаягдлын тухай хуулийн төсөл;

11/ Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын, тухай хуулийн төсөл;

12/ Аж үйлдвэрийн парк байгуулж хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг төсөл;

13/ Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн төсөл;

14/ Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах журмын тухай хуулийн төсөл;

15/ Гэр бүл дэх хүчирхийллийн эсрэг хуулийн төсөл;

16/ Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн шинэчилсэн найруулга;

17/ Бусад.

2. Улсын Их Хурлын 2003 оны намрын чуулганаар хэлэлцэх эсэхийг нь шийдвэрлэсэн, хэлэлцүүлгийн шатанд байгаа хуулийн төслүүдийг дараалал харгалзахгүйгээр хэлэлцүүлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 8 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 195

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 138 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг хавсралт, ёсоор өөрчилсүгэй.

2. "Эмийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм батлах тухай" Засгийн газрын 1998 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 121 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Эмийн үндэсний зөвлөлийн дүрэм"-ийн 2, 10, 11, 12 дугаар зүйлийг дор дурьдснаар өөрчлөн найруулсугай:

1. "2. Үндэсний зөвлөлийг Эрүүл мэндийн дэд сайд тэргүүлэх бөгөөд орлогч дарга нь Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга байна.

2. "10. Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг Эрүүл мэндийн асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн багцдаа багтаан санхүүжүүлэх бөгөөд гишүүдэд хуралд оролцсон цагийг харгалзан зохих урамшуулал олгож болно."

3. "11. Эмийн үндэсний зөвлөл дараахь үүрэгтэй байна.

а/эмийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, түүнд өөрчлөлт оруулах санал боловсруулах;

б/эмийн талаар төрөөс баримтлах бодлого болон хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг жил бүр дүгнэн хэлэлцэх;

в/хүний болон малын зориулалттай эмийн үйлдвэрлэл, импорт, экспорт, хэрэглээний одоогийн байдал, хэтийн төлөвийн талаар зөвлөмж гаргах;

г/эмийн улсын бүртгэл, эмийн чанар, хэрэглээний талаар дүгнэлт гаргах;

д/Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, ажлыг уялдуулах, тайланг хэлэлцэх”

4. “12. Эмийн үндэсний зөвлөл дараахь эрхтэй байна.

а/эмийн талаар төрөөс баримтлах бодлогыг асуудлаар холбогдох байгууллагаас ажлын тайлан, мэдээ, судалгаа, дүгнэлт гаргуулах;

б/эмийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх асуудлаар холбогдох байгууллагад зөвлөмж өгөх;

в/салбар зөвлөлийн шийдвэрийг хянан үзэж, буруу гэж үзвэл хүчингүй болгох;

г/эмийн үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээний чиглэлээр аливаа байгууллагаас

гаргасан шийдвэр нь Эмийн тухай хууль, эмийн талаар төрөөс баримтлах бодлого, олон улсын бусад гэрээ хэлэлцээр, бодлоготой нийцэхгүй гэж үзвэл хүчингүй болгох тухай саналаа зөвхөн байгууллагад тавих;

д/шаардлагатай тохиолдолд эм, эмийн түүхий эдийн чанарыг, магадлах зорилгоор лабораторийн магадлан шинжилгээг холбогдох мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх”

**Монгол Улсын
Ерөнхий сайд**

Н.ЭНХБАЯР

**Эрүүл мэндийн
сайд**

П.НЯМДАВАА

*Засгийн газрын 2002 оны 138 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт*

ЭМИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга - Эрүүл мэндийн дэд сайд

Орлогч дарга - Хүнс, хөдөө аж ахуйн яамны төрийн нарийн бичгийн дарга;

Гишүүд: - Санхүү, эдийн засгийн яамны Төсвийн бодлого зохицуулалтын газрын дарга;

- Хууль зүй, дотоод хэргийн яамны Зохицуулалт, мэдээлэл, хяналт- шинжилгээний газрын дарга;

- Үйлдвэр худалдааны яамны Худалдааны бодлого хамтын ажиллагааны газрын дарга;

- Улсын мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн дарга;

- Улсын мэргэжлийн хяналтын газрын Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын хэлтсийн дарга;

Нарийн бичгийн дарга:

- Эмнэлгийн тусламжийг удирдах газрын Эм зүйн албаны дарга;

- Хүний эмийн салбар зөвлөлийн дарга;

- Малын эмийн салбар зөвлөлийн дарга;

- Эрүүл мэндийн стандартчилалын техникийн хорооны дарга;

- Эрүүл мэндийн яамны эм зүйн ерөнхий мэргэжилтэн;

- Монгол Улсын малын ерөнхий эмч;

- Хүнс, хөдөө аж ахуйн яамны эмийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн;

- Хөдөө аж ахуйн стандартчиллын техникийн хорооны дарга;

- Эрүүл мэндийн яамны Эмийн асуудал хариуцсан мэргэжилтэн.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 8 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 196

Улаанбаатар хот

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 4.3, 6.4, 7.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр Буянт-Ухаа, Сүхбаатар, Алтанбулаг, Замын-Үүд дэх хилийн боомт, Улаанбаатар хот дахь гаалийн газраар нэвтрүүлж байхаар тогтоосугай.

2. Шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалтыг 1 дүгээр, эдгээр бодисыг ашиглах байгууллагын жагсаалтыг 2 дугаар, ашиглах журмыг 3 дугаар, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд болон

бэлтгэх зориулалтын тоног төхөөрөмжийг хадгалах, устгах журмыг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц. Нямдорж, Санхүү, эдийн засгийн сайд Ч. Улаан, Эрүүл мэндийн сайд П. Нямдаваа, Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга Д. Батбаатар нарт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Эрүүл мэндийн сайд

П.НЯМДАВАА

Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ЗОРИЛГООР АШИГЛАХ МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЖАГСААЛТ

А. Мансууруулах эм, бодисын жагсаалт

Олон улсын нэршил	Химийн нэршил
1. Бупренорфин	N(6R,7R,14S)-17-циклопропилметил-7,8-дигидро-7-[(1S)-1-гидрокси-1,2,2-триметилпропил]-6-0-метил-6,14-этано-17-норморфин
2. Героин	диацетилморфин
3. Дигидрокодеин	4,5 эпокси-3-метокси-17-метилморфина
4. D кокаин	
5. Гидроморфон	дигидроморфинон
6. Изометадон	6-диметиламино-5-метил-4,4-дифенил-3-гексанон
7. Каннабиол	6,6,9-триметил-3-пентил-6H-дибензол[bd]пиран 1-ол
8. Каннабидол	1,3 бензенеидол-2-[3-метил-6-(1-метилфенил)-2 циклогексен-1-ил]-5-фентил
9. Катидин	
10. Катинин	
11. Кодеин	3-о-метилморфин
12. Кокаин	бензоилэксгоныны метилэстэр
13. Ксанталин	
14. Лауданозин	
15. Левофанол	(-)-3- гидроксид-N-метилморфинан
16. Меконины хүчил	
17. Морфин	

18. Метадон	6-диметиламино-4,4-дифенил-3-гептанон
19. Наркейн	6-[[6-[2-(диметиламино)этил]-4-метокси-1,3-бензодиоксол-5-ил] ацетил]-2,3-диметокси-бензоины хүчил N-ацетилнаркотин
20. Наркотин	
21. Оксиморфон	14гидроксидигидроморфинон
22. Олий	
23. Фентанил	1-фенетил-4-N-пропиониланилинопи перидин
24. Петидин	1-метил-4-фенилпиперидин-4 карбоксил ацид этил эстэр
25. Тебайн	
26. Тетрагидроканнабинол	7,8,9,10-тетрагидро-6,6,9, триметилбинол 1-3-пентил-6H-дибензол[bd]пиран-1-ол болон бусад изомерүүд
27. Тримеперидин	1,2,5-триметил-4-фенилпропионоксипи перидин
28. Этилморфин	3-О-этилморфин

Б. Сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалт

Олон улсын нэршил	Химийн нэршил
1. Аллобарбитал	5,5 диалилбарбитурын хүчил
2. Амобарбитал	5-этил-5-изопентилбарбитурын хүчил
3. Амфетамин	(+)-6 метилфенэтиламин
4. Барбитал	5,5-диэтилбарбитурын хүчил
5. Бромазепам	7-бromo-1,3-дигидро-5-(2-пиридил)-2H-1,4-бензодиазепин-2-он
6. Гептабарбитал	2,4,6(1H,3H,5H)-пиримидин трион, 5,(1-циклогептен-1-ил)-5-этил



7. Глутетимид	2-этил-2-фенилглутаримид	23. Нордазепам	7-хлоро-1,3-дигидро-5-фенил-2Н-1,4-бензодиазепин-2-нэг
8. Диазепам	7 хлоро-1,3-дигидро-1-метил-5-фенил-2Н-1,4-бензодиазепин-2-он	24. Пентазоцин	(2R*6R*11R*)-1,2,3,4,5,6-гексагидро-6,11-диметил-3-(3-метил-2-бутил)-2,6-метано-3-бензазоцин-8-ол
9. Катинон	(-)-(-S)-2-аминопропиофенон	25. Пентобарбитал	5-этил-5-(1-метилбутил)барбитурын хүчил
10. Клоназепам	5-(о-хлорофенил)-1,3-дигидро-7-нитро-2Н-1,4-бензодиазепин-2-он	26. Оксазепам	7-хлоро-1,3-дигидро-3-гидрокси-5-фенил-2Н-1,4-бензодиазепин-2-нэг
11.(+)-лизергид (LSD)	9,10-дидегидро-N,N-диэтил-6-метилэрголин-8в-карбоксамид	27. Псилоцибин	3-[2-(диметиламино)этил]индол-4-ил дигидроген фосфат
12. Левомепромазин	2-метокси-10-(3-диметиламино-2-метилпропил)-фенотиазин г.х	28. Псилицион	3-[2-(диметиламино)этил]индол-4-ол
13. MDA	(±)N-этил-6-метил-3,4-(метилен диокси) фенетиламин	29. Секобарбитал	5-аллил-5-(метилбутил)барбитурын хүчил
14. MDEA	3,4-метилендиоксизетиламфетамин	30. Трифлуоперазин	10-[3-(4-метил-пиперазинил)пропил]-2(-трифторметил)-10Н-фенотиазин дигидрохлорид
15. MDMA	(±)N-6-диметил-3,4-(метилен диокси) фенетиламин	31. Фенобарбитал	5-этил-5-фенилбарбитурын хүчил
16. Мепробамат	2-метил-2-пропил-1,3-пропанедиол бикарбат	32. Финазепам	7-хлоро-1,3 дигидро-5-фенил-(2 пропил)-2Н-1, 4-бензодиазепин-2-он
17. Медазепам	7-хлоро-2,3-дигидро-1-метил-5-фенил-1Н-1,4-бензодиазепин	33. Фторфеназин	(+)-(S)-N,a-диметилфенетиламин
18. Метамфетамин	2-метил-3-о-толил-4(3Н)-хиназолинон	34. Циклобарбитал	5-(1-циклогексен-1-ил)-5-этилбарбитурын хүчил
19. Метаквалон	метил-а-фенил-2-пиперидинацетат	35. Хлорпромазин	2-хлор-10-(3-диметиламинопропил)-фенатазин гидрохлорид
20. Метилфенидат	3,4,5-триметоксибензоат-2-хлор-10-н3-[1-b-оксиэтил]-пиперазинил-4]-пропил-фенотиазина дифумарат	36. Хлордiazепоксид	7-хлоро-2-(метиламино)-5-фенил-3Н-1,4-бензодиазепин-4-оксид
21. Метафеназат	1,3-дигидро-7-нитро-5-фенил-2Н-1,4-бензодиазепин-2-он	37. Эфедрин	L-1-фенил-2-метиламинопропанол
22. Нитрозепа	бензодиазепин-2-он	Энэхүү жагсаалтад дурдсан бодисуудын давс хамагдана.	

Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоолын 2 дугаар хэвсрэлт

ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ЗОРИЛГООР МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫГ АШИГЛАХ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

Нэг. Эрдэм шинжилгээний байгууллага

1. Эрүүл мэндийн яамны Анагаах ухааны хүрээлэн;
2. Шинжлэх ухааны академийн Хими-технологийн хүрээлэн;
3. Шинжлэх ухааны академийн Ботаникийн хүрээлэн;
4. Мал эмнэлгийн хүрээлэн;

Хоёр.Боловсролын байгууллага

5. Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль;
6. Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал эмнэлэг, биотехнологийн сургууль;
7. Монгол Улсын их сургуулийн Шинэ материал хими-технологийн төв;

Гурав. Бусад

8. Улсын мэргэжлийн хяналтын газрын Нэгдсэн лаборатори;
9. Улсын гаалийн ерөнхий газрын дэргэдэх Гаалийн төв лаборатори;
10. Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийг удирдах газар;
11. Эрүүл мэндийн яамны Сэтгэцийн эмгэг мансуурал судлалын төв;
12. Эрүүл мэндийн яамны Шүүх эмнэлгийн магадлах төв;
13. Мал эмнэлгийн эм бэлдмэл шалгах улсын нэгдсэн лаборатори;
14. Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори;
15. Цагдаагийн ерөнхий газрын Шинжилгээний хүрээлэн.

ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ЗОРИЛГООР МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫГ АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг импортлох

2.1. Шинжилгээ, судалгаанд ашиглагдах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын импортлох зөвшөөрлийг жилийн хэрэгцээний урьдчилсан тооцоог үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тухай бүр олгоно.

2.2. Импортлогч байгууллага нь экспортлогч талтай урьдчилан зөвшилцсөний үндсэн дээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг шинжилгээ, судалгааны зориулалтаар импортлох тухай гэрээ байгуулсан байна.

2.3. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад заагдсан байгууллага эдгээр байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис импортлох тусгай зөвшөөрөл бүхий эм ханган нийлүүлэх байгууллага шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг импортлолж болно.

2.4. Импортлогч байгууллага нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр оруулж ирсэн тухайгаа улсын мэргэжлийн хяналтын байгууллага болон зөвшөөрөл олгогч байгууллагад хуульд заасан хугацаа /7 хоног/-ны дотор мэдэгдэнэ.

Гурав. Шинжилгээ, судалгаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглах

3.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг судалгааны зорилгоор ашиглах байгууллага нь эрдэм шинжилгээний арга зүйг боловсруулан холбогдох эрдмийн зөвлөлөөр батлуулсан байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрхэн хэрэглэх талаар тайлбарыг арга зүйд тусгасан байна.

3.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглан эмнэл зүйн туршилт хийх тохиолдолд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Ёс зүйн хорооноос дүгнэлт гаргуулна.

Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

3.3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис ашиглан судалгаа хийж буй байгууллага нь ажлын явц, үр дүнгийн талаар харьяа удирдах байгууллагад тайлагнаж байна.

3.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис ашиглан шинжилгээ, судалгаа явуулж буй байгууллага нь байгууллага, ажилтны нэрсийг Эрүүгийн цагдаагийн газарт урьдчилан мэдэгдэнэ.

3.5. Эдгээр бодисыг шинжилгээ, судалгаанд ашиглаж буй шат дамжлага бүрт бэлтгэсэн, тэдгээрийг хүлээн авсан, хэрэглэсэн хэмжээ, зарцуулалтын дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.

3.6. Шинжилгээ, судалгааны байгууллагад эдгээр бодисын ашиглалт, зарцуулалтад байгууллагын захиргааны зүгээс дотоод хяналт шалгалтыг тогтмол хийж байна.

3.7. Улсын мэргэжлийн хяналтын байгууллагаас шинжилгээ, судалгааны зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашигладаг байгууллагыг тогтмол хянаж байна.

Дөрөв. Шинжилгээ, судалгааны зориулалтаар мансууруулах үйлчилгээ бүхий ургамал тарималжуулах, ашиглах

4.1. Шинжилгээ, судалгааны зориулалтаар мансууруулах үйлчилгээ бүхий ургамал тарималжуулах, ашиглах тохиолдолд дараахь шаардлага тавигдана:

4.1.1. ургамлыг тарималжуулах газар, талбайн хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар тогтоолгосон байх;

4.1.2. тухайн ургамлыг ашиглаж болох тухай болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, дүгнэлт гаргуулсан байх.

Тав. Тайлан гаргах

5.1. Шинжилгээ, судалгааны зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис ашиглах байгууллага нь дараа онд импортлох шаардлагатай эм, бодисын нэр төрөл, тоо хэмжээг тооцон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 1 дүгээр улиралд багтаан ирүүлнэ.

5.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглаж буй байгууллага нь импортлосон, хэрэглэсэн бодисын талаархи тайланг улирлаар гарган улирал бүрийн эхний сарын 10-ны дотор зөвшөөрөл олгогч байгууллагад ирүүлнэ.

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИС, ТЭДГЭЭРИЙН ТҮҮХИЙ ЭД БОЛОН БЭЛТГЭХ ЗОРИУЛАЛТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ХАДГАЛАХ, УСТГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд болон бэлтгэх зориулалтын тоног төхөөрөмжийг хадгалах, устгахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хадгалах

2.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг эдгээр эм, бодисыг үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл бүхий байгууллага (цаашид "тусгай зөвшөөрөл бүхий байгууллага" гэх), шинжилгээ, судалгаа, эрх бүхий хуулийн болон эмнэлгийн байгууллага хадгална.

2.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хадгалахад дараахь шаардлагыг хангасан байна:

2.2.1. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний түүхий эдийг дохиоллын системээр тоноглогдсон байранд буюу цоожтой төмөр шүүгээнд /техникийн хувьд бэхжүүлсэн/ хадгалах;

2.2.2. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн нэр, хэмжээ, үйлдвэрлэгчийн нэр, цувралын дугаар, хүчинтэй хугацааг заасан хаяг, шошго бүрэн, үйлдвэрийн савалгааг өөрчлөөгүй байх;

2.2.3. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бичил биетийн нөлөөгөөр гэмтэх болон харилцан бохирдохоос сэргийлж зохих арга хэмжээг авсан байх;

2.2.4. байгууллагын захиргаанаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний түүхий эдийг хадгалдаг байранд нэвтрэх эрх бүхий ажилтныг томилон, ерөө, төмөр шүүгээний түлхүүрийг эд хариуцагч, лацны тэмдгийг хариуцлагатай албан тушаалтан хадгалдаг байх;

2.2.5. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хүлээж авах, хуваах, жижиглэн савлах зэрэг үйл ажиллагааг байгууллагаас томилсон байнгын комиссын хяналтын дор тодорхой хугацаанд гүйцэтгэж тэр тухай актыг тухай бүр үйлдэж байх;

Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

2.2.6. өөрийн ашиглаж, хадгалж буй бодисын тооллогыг сар бүр хийж байх;

2.2.7. байгууллага нь бэлтгэсэн бодис, түүний нөөц, орлого, зарлага болон хүлээн авагчийн тухай дэлгэрэнгүй бүртгэлийг тухай бүрт бүртгэнэ. Энэхүү бүртгэлийг 2 жилээс доошгүй хугацааны турш хадгална.

2.3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг эмнэлгийн байгууллагад хадгалахдаа 2.2-т заасан журмаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:

2.3.1. эмнэлэгт шаардлагатай мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг эмнэлгийн эмийн санд хадгалдаг байх;

2.3.2. эмнэлгийн тасаг хэрэгцээг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг 2 едрийн хэрэгцээнээс ихгүй хэмжээгээр цоожтой шүүгээнд хадгалах;

2.3.3. мансууруулах эмийг өвчтөнд хэрэглэсэн тухай бүр эмийн тун, цувралын дугаар, хэрэглэсэн аргыг өвчний түүхэнд тодорхой бичиж сувилагч, тасгийн бага эмч, тасгийн эрхлэгч гарын үсэг зурсан байх;

2.3.4. тасаг нь эмийн зарцуулалтын бүртгэл хөтөлж байх бөгөөд уг бүртгэлийг 2-оос доошгүй жил хадгалах;

2.3.5. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын зарцуулалтыг эмнэлгийн эмийн сангийн тайланд тусгана.

Гурав. Тайлан гаргах

3.1. Тусгай зөвшөөрөл бүхий байгууллага дараа онд импортлох шаардлагатай мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр төрөл, тоо хэмжээг тооцон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 1 дүгээр улиралд багтаан ирүүлнэ.

3.2. Тусгай зөвшөөрөл бүхий байгууллага нь импортлосон, хэрэглэсэн бодисын талаархи тайланг улирлаар гарган улирал бүрийн эхний сарын 10-ны дотор зөвшөөрөл олгогч байгууллагад ирүүлнэ.

Дөрөв. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг устгах

4.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт



бодисын эргэлтэд хяналт тавих тухай" хуулийн 7.2-т заасан тохиолдолд устгах арга хэмжээ авна.

4.2. Хууль бус эргэлтээс хураан авсан, эмчилгээ, шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах боломжгүй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар устгана.

4.3. Тусгай зөвшөөрөл бүхий байгууллага, шинжилгээ, судалгааны байгууллага нь хүчинтэй хугацаа дууссан, химийн болон физикийн үйлчлэлийн улмаас нөхөн сэргээх, дахин боловсруулах боломжгүйгээр шинж чанараа алдсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг устгахдаа дараахь нөхцөлийг хангасан байна:

4.3.1. улсын мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн байгууллагын даргын шийдвэрээр тусгай комисс томилох;

4.3.2. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг устгахдаа улсын мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөллийг байлцуулах;

4.3.3. устгасан тухай баримт бичиг үйлдэн улсын мэргэжлийн хяналтын байгууллагад хуулбарыг хүргүүлэх.

4.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг устгахдаа түүний шинж чанар, ангиллаас хамаарч шатаах, саармагжуулсны дараа бохир ус зайлуулах шугамд хаях, булах, булшлах зэрэг аргын аль тохирохыг хэрэглэнэ.

Тав. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх тоног төхөөрөмжийг хадгалах, устгах

5.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх тоног төхөөрөмжийг зөвхөн эдгээр эм, бодис, түүхий эдийг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллага, аж ахуйн нэгж хадгалж ашиглана.

5.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хууль бусаар бэлтгэхэд ашиглаж байсан тоног төхөөрөмжийг цаашид ашиглах боломжгүй нь улсын мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтээр тогтоогдвол Цагдаагийн ерөнхий газрын даргын шийдвэрийн дагуу тусгай комисс томилон устгаж, нотломж үйлдэн холбогдох газарт танилцуулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр

Дугаар 198

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2003 оны 26 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 2002 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 162 дугаар тогтоолын хавсралтад Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "З. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар" гэснийг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн

газрын тохируулагч агентлаг "З1. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар" гэж өөрчилсүгэй.

Монгол Улсын
Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын
дарга

Ө.ЭНХТҮВШИН

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар- 12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 1